

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019 он

**БАТЛАВ: ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,**

**ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН**

**ДАРГА Ц.ГАНХҮҮ**

Хөтөлбөр (хөтөлбөрийн нэр), хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгжийн нэр
	Арга хэмжээ (гарц)-ний шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшин	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	
1	2	3	4
<b>"Нэг. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодезийн бүх төрлийн сүлжээ, байр зүйн болон сэдэвчилсэн тоон зураглалын тогтолцоог байгуулж, хэрэглээг арга зүйгээр хангах" гэсэн байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>			
<p>“1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт зохицсон байрлал, өндрийн нэгдсэн сүлжээ байгуулж зураглалын үндэслэлээр хангах” үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:</p> <p>1. Нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтүүдийн бүрэн бүтэн байдал, газар олголт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд устах, гэмтэх магадлалтай эсэхэд хяналт</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Хууль, “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” БД 11-104-06 болон холбогдох бусад дүрмийн шаардлага хангасан байх</p> <p><b>Хугацаа:</b> 2019.10.15-ны дотор</p>	<p>Аймгийн цэг, тэмдэгтийн тооллогын мэдээллийг ГЗБГЗЗГ-г хүргүүлсэн байна. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийн 5.8.2 дахь заалт хэрэгжинэ.</p>	<p>ГУХ</p>

<p>тавих, тооллого хийх ажлыг зохион байгуулж үр дүнг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>			
<p>1.1.2. Оршин суух нутаг дэвсгэр дээр нь байрлаж буй Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг гэмтээх, устгах магадлал бүхий бүтээн байгуулалтын ажил явагдаж буй талаарх мэдээллийг иргэд, олон нийт сайн дураараа ирүүлдэг байх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийж, холбогдох мэдээллийг бүрдүүлэх</p>	<p><b>Тоо хэмжээ: 1-2 сурталчилгаа</b></p> <p><b>Чанар: Хууль, дүрмийн шаардлага хангасан байх</b></p> <p><b>Хугацаа: 3-5 сар</b></p>	<p>Устах болон гэмтэх эрсдэлтэй геодезийн байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийг иргэд олон нийтээс авдаг болсон байна. Геодези, зураг зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн 10.4.4 дэх заалт хэрэгжинэ.</p>	<p>ГУХ</p>
<p>1.1.3. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг гэмтээсэн, устгасан, хэмжилт хийх нөхцлийг алдагдуулсан этгээдийг олж тогтоон, зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулан нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах, тотмол хяналт тавих,</p>	<p><b>Тоо хэмжээ: Устсан цэгийн тоогоор</b></p> <p><b>Чанар: Хууль, дүрмийн шаардлага хангасан байх</b></p> <p><b>Хугацаа: Тухай бүр</b></p>	<p>Устсан болон гэмтсэн цэг, тэмдэгтийг шинээр суулгаж, байрлал, өндрийн /гравиметрийн цэгт гравиметрийн утга тодорхойлох/ утгыг тодорхойлж, нөхөн сэргээсэн байна. Геодези, зураг зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн 10.4.4 дэх заалт хэрэгжинэ.</p>	<p>ГУХ</p>
<p>1.1.4. Асуудал хариуцсан мэргэжилтнээр геодезийн байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн санд цэг тэмдэгтийн тооллогын мэдээллийг батлагдсан загварын дагуу бэлтгэж оруулах, оруулуулах, хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p><b>Тоо хэмжээ: Аймгийн хэмжээнд</b></p> <p><b>Чанар: Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн сангийн загварт нийцсэн байх</b></p> <p><b>Хугацаа: 9-10 сар</b></p>	<p>2019 онд хийгдсэн тооллогын мэдээлэл цэг тэмдэгтийн мэдээллийн санд оруулсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>1.1.5. Байнгын ажиллагаатай станцын сүлжээнд гарч байгаа доголдлыг тодорхойлж, гарсан доголдлын талаар тухай бүр ГЗБГЗЗГ-т мэдэгдэх, шалтгааныг тодорхойлж зохих арга</p>	<p><b>Тоо хэмжээ: Аймгийн хэмжээнд</b></p> <p><b>Чанар: Станцууд тасалдалгүй</b></p>	<p>БАС тасалдалгүй ажиллаж, хэрэглэгчдийг хэмжилт хийх нөхцөл бололцоогоор хангасан байна. БАС-ын өдөр тутмын</p>	<p>ГУХ</p>

хэмжээ авах, станцын өгөгдлийг татах, татаж серверт байршуулах ажлыг зохион байгуулах	ажиллах <b>Хугацаа:</b> 1-12 сард /сар бүрийн 05-ны өдөрт багтаан өгөгдлийг серверт байршуулах/	өгөгдлийг дараа сарын 05-ны өдөрт багтаан хадгалсан байна.	
1.1.6. Асуудал хариуцсан мэргэжилтнийг GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийн туршилтад оролцуулах, хэрэгжилтэд хяналт тавих	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн төвийн гравиметрийн цэг <b>Чанар:</b> Хэмжилтийн өгөгдөл тасалдалгүй байх <b>Хугацаа:</b> 8 сард	Аймгийн төвийн гравиметрийн цэг дээр 4 цагийн тасалдалгүй хэмжилт хийж онлайн боловсруулалтын системээр бодуулж үр дүнг урьд өмнөх бодолтын үр дүнтэй харьцуулах бөгөөд хэмжилтийн өгөгдөл болон харьцуулсан үр дүнг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	ГУХ
1.1.7. Тухайн орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажлын геодезийн хэмжилт, зураглалын ажил холбогдох хууль, дүрэмд нийцсэн эсэхэд хяналт тавих, тэдгээр ажлуудыг геодезийн байнгын цэг тэмдэгт, байр зүйн дэвсгэр зураг зэрэг шаардлагатай мэдээллээр ханган гүйцэтгэлийг шалгаж хүлээн авах, ГЗБГЗЗГ-т мэдэгдэх	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Мөрдөж буй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 1-12 сард	Орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын геодезийн хэмжилт, зураглалын ажил холбогдох хууль, дүрэмд нийцсэн хяналт тавигдсан, гүйцэтгэлийг шалгаж хүлээн авч ГЗБГЗЗГ-т мэдэгдсэн байна.	ГУХ
1.1.8. Орон нутагт геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөлтэй эсэх, геодезийн хэмжлийн багаж хэрэгслээ баталгаажуулсан эсэх, хэмжлийг солбицол өндрийн нэгдсэн тогтолцоонд хийсэн эсэхэд хяналт тавих	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Холбогдох хууль, дүрмийн дагуу <b>Хугацаа:</b> 1-12 сард	Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрөл, багаж баталгаажуулалт, гүйцэтгэж буй ажилд хяналт тавина.	ГУХ
1.1.9. Агентлагаас хүргүүлсэн “Монгол улсын геодезийн сүлжээ” сэдэвт телевизийн 10 минутын нэвтрүүлгийг орон нутгийн телевиз, радиогаар нэвтрүүлж олон нийтэд сурталчлах	<b>Тоо хэмжээ:</b> 2-3 удаа <b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан	“Монгол улсын геодезийн сүлжээ” сэдэвт нэвтрүүлэг орон нутгийн телевизээр нэвтрүүлэгдсэн, иргэд геодезийн сүлжээ, цэг тэмдэгтийн	ГУХ

	байх <b>Хугацаа: 5-10 сард</b>	талаар тодорхой ойлголт авсан байна.	
“1.2. Жижиг, дунд, том масштабын /газар дээрх болон доорх биетийн/ байр зүйн тоон зургаар хангах” үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:  1.2.1. Аймаг, сумын төв, томоохон суурингийн 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зургийг агентлагийн холбогдох хэлтэстэй хамтран MNS 6702:2017 стандартад нийцүүлэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих,	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн төв, нийт сум, суурин <b>Чанар:</b> MNS 6702:2017 Стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 3-6 сард	1:1000-ны масштабын байр зүйн тоон зургийг MNS 6702:2017 стандартын дагуу таних тэмдэгжүүлэн, хэрэглээнд нэвтрүүлэх боломж бүрдсэн байна.	ГУХ
1.2.2. Аймаг, сумын төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зурагт шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объектын мэдээллийг тухай бүр оруулан мэдээллийн санг шинэчлэн баяжуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн төв, нийт сум, суурин <b>Чанар:</b> Тоон зургийн стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 5, 10 сард	Байр зүйн тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хэмжилт болон гүйцэтгэлийн зургаар тогтмол шинэчилж ГЗБГЗЗГ-т заасан хугацаанд 2 удаа хүргүүлсэн байна.	ГУХ
1.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр бүтээн байгуулалтын ажил нь хийгдэж байгаа авто зам, төмөр зам, шилэн кабель, холбоо цахилгааны шугам тавих зэрэг ажлын талаар ГЗБГЗЗГ-т мэдэгдэх, орон нутгийнхаа холбогдох байгууллагатай энэ чиглэлээр мэдээлэл солилцох, хамтын ажиллагаа өрнүүлэх талаар хамтран ажилласан байх	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 1-12 сард	Орон нутагт хийгдэж буй ажлын талаарх мэдээллийг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. Орон нутгийн байгууллагууд геодези, зураг зүйн ажлын талаар тодорхой мэдлэгтэй болсон төдийгүй мэдээллээ солилцдог болсон байна.	ГУХ
1.2.4. Агентлагаас өгсөн зааварчилгааны дагуу аймгийн хэмжээнд байгаа өндөр барилга, байгууламжийн судалгаа хийх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих,	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Норм, дүрэмд нийцсэн байх	Аймгийн хэмжээнд өндөр барилга байгууламжийн судалгааг хийж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	ГУХ

ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	<b>Хугацаа:</b> 4-10-р сар		
1.2.5 Агентлагаас хүргүүлсэн “Монгол орны зурагжуулал” сэдэвт ТВ-ийн 10 минутын нэвтрүүлгийг орон нутгийн телевизээр нэвтрүүлж олон нийтэд сурталчлах	<b>Тоо хэмжээ:</b> 2-3 удаа <b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 5-10 сард	Монгол орны зурагжуулалтын талаар нэвтрүүлэг орон нутгийн телевизээр нэвтрүүлэгдсэн, иргэд байр зүйн зургийн талаар тодорхой ойлголт авсан байна.	
“1.3. Бүх төрлийн масштабын сэдэвчилсэн тоон зураглалын ажлуудыг баталгаат сууриар хангах” үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:  <u>1.3.1.</u> 1:1000-ны масштабтай хаягийн зургийг шинэчлэн, нэр дугаар хаяг авсан гудамж, зам талбай, шинээр баригдсан байшин барилга, үл хөдлөх хөрөнгө зэргийг оруулан баяжуулж 2019 оны 12 дугаар сарын 01-ны дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлэх, хаягийн зургаар байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих,	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Тоон зургийн стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 5, 10 сард	Шинэчлэгдсэн хаягийн зураг, мэдээллийн сангийн мэдээллийг заасан хугацаанд 2 удаа ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. Хаягийн зургаар хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	ГУХ
<u>1.3.2.</u> 1:100 000-ны масштабтай хаягийн зургийн мэдээллийн санг нутаг дэвсгэр дэх түүх соёл, байгалийн дурсгалт газар, үл хөдлөх хөрөнгө (өвөлжөө, хаваржаа, амралт сувиллын газар), түүнд хүрч очих авто замууд, тэдгээрт гарсан өөрчлөлтөөр шинэчлэн баяжуулж 2019 оны 12 дугаар сарын 01-ны дотор ГЗБГЗЗГ-т хүргүүлэх	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Тоон зургийн стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 5, 10 сард	Хаягийн зургийг түүх соёл, байгалийн дурсгалт газар, үл хөдлөх хөрөнгө (өвөлжөө, хаваржаа, амралт сувиллын газар), түүнд хүрч очих авто замууд, тэдгээрт гарсан өөрчлөлтөөр баяжуулан хаягийн мэдээллийн санг шинэчилж заасан хугацаанд 2 удаа ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.	ГУХ
1.3.3. Шинээр байгуулсан суурин, хороолол, гудамж, зам, талбайд нэр, дугаар, хаяг өгч	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд	Шинээр байгуулсан суурин, хороолол, гудамж, зам, талбай нь	ГУХ

<p>баталгаажуулах ажлыг “Геодези, зураг зүйн тухай”, “ Хаягжуулалтын тухай” хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулж, хаягийн зурагт оруулан мэдээллийн санг баяжуулах, хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p><b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх</p> <p><b>Хугацаа:</b> 5, 10 сард</p>	<p>холбогдох хууль болон ЗГ-ын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу нэр, дугаар, хаяг өгөгдсөн, ИТХ-аар баталгаажсан, хаягийн зурагт оруулсан хаягийн мэдээллийн санг баяжуулсан байна.</p>	
<p>1.3.4. Орон нутгийн төсөвт хаягийн тэмдгийг суурилуулах ажлын зардлыг тусгах, зарим томоохон аж ахуйн нэгжээс /тухайлбал: уул уурхай, амралт, аялал жуулчлалын газар гэх мэт суурин газраас алслагдмал байрлалтай/ хаягийн тэмдгийг суурилуулах ажлын зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрнөгийг хаягжуулах журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу гаргуулах, хаягийн тэмдэг, тэмдэглэгээг суурилуулах ажлыг зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх</p> <p><b>Хугацаа:</b> 1-10 сард</p>	<p>Орон нутгийн төсөвт хаягийн тэмдгийг суурилуулах ажлын зардлыг тусгуулах ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн хаягийн тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн, газарт суурилуулагдсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>1.3.5. Агентлагаас хүргүүлсэн 18 аймгийн “Хаягийн атлас”-ыг хэрэглээнд нэвтрүүлж, өөрийн аймгийн шинэчлэгдсэн хаягийн зургаар “Хаягийн атлас”-ыг зохиож, хэвлэх ажлын зардлыг орон нутгийн 2020 оны төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 18 аймгийн хаягийн атлас, 1 төсвийн санал</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх</p> <p><b>Хугацаа:</b> 1-10 сард</p>	<p>18 аймгийн “Хаягийн атлас”-ыг хэрэглээнд нэвтрүүлсэн, “Аймгийн хаягийн атлас”-ыг зохиож, хэвлэх ажлын зардал шийдэгдсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>“1.4. Монгол орны газар зүйн нэрийг тодотгон тогтоох, газар зүйн нэрийг баяжуулах ажлыг удирдах” үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:</p> <p>1.4.1. Газар зүйн нэрийн аймаг дахь салбар</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 1</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх</p>	<p>Газар зүйн нэрийн аймаг дахь салбар зөвлөл байгуулж, дүрмийг батлуулсан байна. Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлыг ГЗБГЗЗГ-г хүргүүлсэн байна.</p>	<p>ГУХ</p>

<p>зөвлөлийг байгуулах ажлыг зохион байгуулах, Газар зүйн нэрийн Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж УИХ, ЗГ-т танилцуулах, батлуулах газар зүйн шинэ нэр, өөрчилөгдсөн нэрийн талаархи асуудлыг боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>	<p><b>Хугацаа:</b> 6-11 сард</p>		
<p>1.4.2. Монгол орны газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын төсвийг орон нутгийн төсөвт суулгах ажлыг зохион байгуулах, 1 сумын газар зүйн нэрийн мэдээллийн сан үүсгэх ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 5-12 сард</p>	<p>Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаварыг ГЗБГЗЗГ-тай хамтран боловсруулж орон нутгийн төсөвт тусгуулах ажил зохион байгуулсан байна. 1 сумын газар зүйн нэрийн мэдээллийн санг батлагдсан загвараар үүсгэж, ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>1.4.3. Газар зүйн нэрийг зөв нэрлэж хэвшүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, энэ талаар сумдын Газрын даамлуудад чиглэл өгөх, үр дүнгийн гэрээнд нь тусгах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан байх <b>Хугацаа:</b> 9-10 сард</p>	<p>Газар зүйн үнэн, зөв нэрийг олон нийтэд таниулан сурталчлах, зөв нэрээр нэрлэж хэвшүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>“1.5. Салбарын хэрэглэгчдийн хэрэгцээт бүтээгдэхүүнийг тодорхойлж байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх төсөл, хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тэдгээрийг хамтын хэлэлцүүлэгт оруулж баталгаажуулах, хэрэгжилтийг хангах” үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:  1.5.1. Геодези, зураг зүйн тухай хуулийн</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 1 <b>Чанар:</b> Хууль тогтоомжид нийцсэн байх <b>Хугацаа:</b> 1-4-р сар</p>	<p>Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгсөн байна.</p>	<p>ГУХ</p>

шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх			
1.5.2. Геодези, зураг зүйн салбарын удирдах ажилтны II зөвлөгөөнд оролцох	<p><b>Тоо хэмжээ: 1</b></p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> 4-5-р сар</p>	Удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон байна.	ГУХ
1.5.3. Орон нутгийн геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг агентлагаас зохион байгуулах сургалтад хамруулах	<p><b>Тоо хэмжээ: 1</b></p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> 4-5-р сар</p>	Орон нутгийн геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн сургалтад хамрагдсан байна.	ГУХ
1.5.4. Геодези, зураг зүйн чиглэлээр агентлагийн мэргэжилтнүүдийн хийсэн судалгаатай танилцах, шинэ санааг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, цаашдын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх санал боловсруулах,	<p><b>Тоо хэмжээ: 1</b></p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> 5-6-р сар</p>	Геодези, зураг зүйн гадаад, дотоодын судалгаатай танилцаж, зарим санал, санаачлагуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, цаашдын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх санал боловсруулсан байна.	ГУХ
1.5.5 Геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбоотой албан бичиг болон яаралтай ажлуудыг шийдвэрлэж хэрэгжүүлэх	<p><b>Тоо хэмжээ: 1</b></p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> Тухай бүр</p>	ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбоотой албан бичиг, яаралтай ажлуудыг тухай бүх шийдвэрлэсэн байна.	ГУХ
<p><b>"Хоёр. Улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулж, улсын хэмжээнд нэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргах, салбар дундын суурь судалгаа, мониторингийн мэдээллийн сан байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх, газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>			
2.1.1. Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын	<b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд	Аймгийн хэмжээнд газрын нэгдмэл	ГУХ



<p>төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээ байгуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, дүгнэлтийг агентлагт ирүүлэх</p>	<p><b>Чанар:</b> ажлын даалгаврын шаардлага хангасан байх</p> <p><b>Хугацаа:</b> 1-10 сар</p>	<p>сангийн мониторингийн сүлжээ, цэгийг байгуулсан байна. Хээрийн ажлыг шалгаж дүгнэлтийг агентлагт ирүүлсэн байна.</p>	
<p><u>2.1.2.</u> Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд сум бүрээр зохион байгуулах, энэ ажилд шаардагдах зардлыг шийдвэрлэх, ажлын үр дүнг нэгтгэн агентлагт ирүүлэх</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Газрын даргын 2015 оны А/105 тоот тушаалаар баталсан журам, зааврын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 5-10 сар</p>	<p>Сум бүрт бэлчээрийн фотомониторингийн үр дүнг боловсруулж, аймгийн хэмжээнд тайланг агентлагт ирүүлсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p><u>2.1.3.</u> Бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын 2018 оны үр дүнг ашиглан аймгийн бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал болон бэлчээрийн экологийн чадавхийн зураглалыг шинээр хийх</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 3-5 сумын хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Газрын даргын 2015 оны А/103 тушаалаар баталсан журам, 2017 оны А/268 тоот тушаалаар баталсан зааврын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 3-6 сард</p>	<p>Сумдын бэлчэрэийн сэргэх чадавхийн ангилалын болон бэлчээрийн экологийн чадавхийн зураглалыг хийж агентлагт ирүүлсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>2.1.4. Газрын тухай хуулийн 58-р зүйлд заасны дагуу хөрс, орчны бохирдол ихээр үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 4-10 сард</p>	<p>Захиалагт хянан баталгааны ажлыг 50-иас доошгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хийлгэсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p><b>"Гурав. Иргэд, олон нийтийн оролцоо, салбар хоорондын уялдаа холбоог хангасан, геологи, хүрээлэн буй орчны төлөв байдал, байгалийн нөхцөл, нөөцийн иж бүрэн мэдээлэлд суурилсан тогтвортой газар ашиглалтыг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн сан, удирдлагын нэгдсэн системийг байгуулж, хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах" гэсэн байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>			

<p>"3.1. Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах" үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:</p> <p>3.1.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний талаарх сургалтад бүх салбаруудыг хамруулах ажлыг орон нутагт зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-3 сард</p>	<p>Бүх салбарууд улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдээлэлтэй болсон байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.1.2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний заагдсан үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх салбарыг оролцуулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Ерөнхий сайдын захирамжаар батлагдсан улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийцсэн байна.</p> <p><b>Хугацаа:</b> 1-6 сард</p>	<p>Аймгийн холбогдох салбаруудыг хамруулсан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.1.4. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах зардлыг төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулах.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журам, заавар, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн байна.</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 сард</p>	<p>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зардл орон нутгийн төсөвт тусгагдсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.1.7. 2018 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авах, нэгтгэх, 2019 оны төлөвлөгөөг загварын дагуу ГЗБГЗЗГ-т хүргүүлэх.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-2 сард</p>	<p>Сумдын 2018 оны төлөвлөгөөний биелэлт, 2019 оны төлөвлөгөө улсын хэмжээнд нэгтгэгдэж ГЗБГЗЗГ-т хүргэгдсэн байна.</p>	<p>ГУХ</p>

<p>3.1.8. Аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн, сумын газрын даамлуудад зориулсан газар зохион байгуулалтын мэдээллийн сангийн цахим системийн хэрэглэгчийн түвшний сургалтыг ГЗБГЗЗГ-тай хамтран зохион байгуулах.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд 1 сургалт</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 5-11 сард</p>	<p>Сургалт зохион байгуулсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.1.9. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн сан, цахим системийг турших, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг ГЗБГЗЗГ-тай хамтран орон нутагт зохион байгуулах, шаардлагатай мэдээ, судалгаагаар агентлагийг хангах.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 21 аймаг, нийслэл</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 сард</p>	<p>Туршилт сайжруулалт хийгдсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.1.10. Аймгийн ГЗБЕТ, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг боловсруулах, газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажлыг зохион байгуулах, уг ажилд шаардагдах төсөв зардлыг шийдвэрлүүлэх</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 сард</p>	<p>Хэсэгчилсэн төлөвлөгөөний ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл хийгдэж, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхэд бэлэн болсон байна.</p>	<p>ГУХ</p>
<p>"3.2. "Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг байгалийн нөхцөл, нөөц, нийгэм эдийн засгийн суурь судалгааны мэдээлэлд үндэслэн газрын ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, газрын хэрэгцээт байдлын үнэлгээг хийх түүнд нийцүүлэн газар ашиглалтыг оновчтой төлөвлөх замаар газрын тогтвортой менежментийг бий болгож хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих" үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 сард</p>	<p>Засгийн газрын тогтоол хэрэгжсэн байна.</p>	<p>ГУХ</p>

<p>3.2.1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах</p>			
<p>3.2.2. Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх хүсэлтийн хамт ИТХ-аар хэлэлцүүлэн, ГЗБГЗЗГ-т 12 дугаар сарын 5-ны дотор хүргүүлэх.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу <b>Хугацаа:</b> 11-12 сард</p>	<p>2020 өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг ИТХ-аар хэлэлцүүлж ГЗБГЗЗГ-т ирүүлсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.2.3. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын ач холбогдол, хэрэгцээ шаардлагын талаар орон нутгийн удирдлагад мэдээ, мэдээлэл өгч, шаардлагатай төсөв зардлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу <b>Хугацаа:</b> 1-12 сард</p>	<p>СНДХТ боловсруулах зардал орон нутгийн төсөвт суусан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.2.4. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын бүх шатанд хяналт тавих, сумдын газрын даамал, мэргэжлийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага, арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж, ажлын явцыг тухай бүр ГЗБГЗЗГ-т мэдээлж, хамтран ажиллах.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Баян-Өлгий аймгийн <i>Толбо</i> <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу <b>Хугацаа:</b> 1-12 сард</p>	<p>10 сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.2.5. Урьд өмнө хийгдсэн сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын тайлан, төлөвлөгөөний зургийн тоон мэдээллийг зохих заавар, аргачлалын дагуу ГЗБГЗЗГ-т ирүүлж холбогдох дүгнэлт саналыг авч, дүгнэлтийн дагуу тайланг, засварлаж ГЗБГЗЗГ-т хүлээлгэн өгөх.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Баян-Өлгий аймгийн <i>Толбо</i> <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, журам, заавар, арга зүйн дагуу <b>Хугацаа:</b> 1-3 сард</p>	<p>Засаж сайжруулан ГЗБГЗЗГ-т хүлээлгэн өгсөн байна.</p>	<p>ГУХ</p>

<p>"3.4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалт, хилийн цэсийн асуудлыг эрхлэх" үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:</p> <p>3.4.1. Аймгийн төвийн сумдын хилийг тэлэх асуудал болон бусад хилийн цэсийн маргааныг “Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар”-ын дагуу бууруулах арга хэмжээ авч, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-9 сард</p>	<p>Аймгийн төвийн сумдын тэлэх шаардлагатай хилийн зааг тодорхой болж, хилийн маргаан буурсан байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.4.2. Хилийн цэсийн бодит болон бодит бус маргаантай байгаа газруудын судалгааг ГЗБГЗЗГ-аас хүргүүлсэн загварын дагуу аймгийн хэмжээнд нэгтгэж ирүүлэх.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 2-11 сард</p>	<p>Орон нутгийн удирдлага, иргэд хилийн цэсийн үнэн бодит мэдээллээр хангагдаж, аймгийн төвийн сумдын хилийн цэсийн судалгаа нэгтгэгдэн дээд шатны байгууллагад хүргэгдсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.4.3. “Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар”-ын дагуу “голын голдирол, жалга, уулыг хярлах” зэрэг зарлиг, тогтоолд тодорхой чиглэл заасан эргэлтийн цэгүүдийн шугамыг агаар, сансрын зураг ашиглан нарийвчлан тодорхойлж ГЗБГЗЗГ-т хүргүүлэх.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Аймгийн хэмжээнд</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 2-6 сард</p>	<p>1:100000 масштабтай байр зүйн зурагт суурилсан хилийн цэсийн шугамыг агаар сансрын зураг ашиглан тодорхойлж ГЗБГЗЗГ- т хүргэсэн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>3.4.4. “Баг, хорооны хилийн зааг тогтоох, баталгаажуулах” зааврын дагуу баг, хорооны хилийн заагийг тогтоох ажлыг зохион байгуулан сумын ИТХ-аар батлуулж, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх.</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 2 аймаг /Булган, Баян-Өлгий/</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжийн дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 2-11 сард</p>	<p>Сумдын багийн хилийн заагийн солбицол аймгийн ИТХ-аар хэлэлцэгдэн батлагдсан байна.</p>	<p>ГУХ</p>

"Дөрөв. Нийт нутаг дэвсгэр дээрх эдлэн газар, үл хөдлөх хөрөнгийг төрийн өмнөөс кадастрын хэмжилт, зураглал, хаягжилт, бүртгэлээр баталгаажуулах, байрлал бүхий үл хөдлөх хөрөнгийн иж бүрэн мэдээллийн сан, хувийн хэрэг, газрын бирж, үнийн мэдээ, үнэлгээ, төлбөр, татварын тогтолцоог байгуулж, төрийн нэрийн өмнөөс хэрэглэгчийг баталгаат мэдээллээр хангах" гэсэн байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

<p>4.1. “Нийт нутаг дэвсгэр дэх газар дээрх үйл ажиллагааны зориулалтын эрх тус бүрээр газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн газрын кадастрын нэгдсэн мэдээллийн тогтолцоог байгуулах ажлыг удирдаж (төлөвлөх, зохион байгуулах, хянах), газрын улсын бүртгэлд бүрэн хамруулж төрийн нэрийн өмнөөс баталгаажуулах, санхүү бүртгэлд тусгах, хөрөнгийн эрхийг баталгаажуулах, хөрөнгийн баталгаа болгох, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломж нөхцлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх” үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:</p> <p>4.1.1. Газрын улсын бүртгэл, кадастрын зураглалтай холбоотой журам, заавар, аргачлалын төсөлд санал боловсруулж, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>	<p style="text-align: center;"><b>Тоо хэмжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Иргэнд өмчлүүлэх газрын кадастр хийх журам”-ын төсөл</li> <li>• ГХГЗЗГ /хуучин нэрээр/-ын даргын 2008 оны 133 тоот тушаалаар батлагдсан “Өргөдөл, Өргөдлийн дэвтэр, Өргөдөл хүлээн авсан тухай тодорхойлолт, Хариу өгөх мэдэгдэл, Итгэмжлэл”-ийн загварын төсөл</li> </ul> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> 1-11 дүгээр сар</p>	<p>“Иргэнд өмчлүүлэх газрын кадастр хийх журам”, “Өргөдөл, Өргөдлийн дэвтэр, Өргөдөл хүлээн авсан тухай тодорхойлолт, Хариу өгөх мэдэгдэл, Итгэмжлэл”-ийн төслүүдэд санал өгсөн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>4.1.2. Газрын кадастрын мэдээллийн сантай холбоотой журам, заавар, аргачлалын төсөлд санал боловсруулж, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>	<p style="text-align: center;"><b>Тоо хэмжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• “Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам”-ын нэмэлт өөрчлөлтийн төсөл;</li> </ul> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> Тухай бүр</p>	<p>“Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах журмын төслүүдэд санал өгсөн байна.</p>	<p>ГУХ</p>

<p>4.1.3. Газрын төлбөр, татвартай холбоотой журам, заавар, аргачлалын төсөлд санал боловсруулж, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> “Газрын төлбөр, албан татвар төлөгчийн мэдээллийн санг хөтлөх, тайлан мэдээ гаргах журам”-ын төсөл</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх</p> <p><b>Хугацаа:</b> 1-3 дугаар сар</p>	<p>“Газрын төлбөр, албан татвар төлөгчийн мэдээллийн санг хөтлөх, тайлан мэдээ гаргах журам”-ын төсөлд санал өгсөн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>4.1.4. Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн веб хувилбарыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох мэргэжилтэн, албан хаагчдыг сургалтанд хамруулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 1</p> <p><b>Чанар:</b> Програм хангамжийн хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 дугаар сар</p>	<p>Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн веб хувилбарыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох мэргэжилтэн, албан хаагчдыг сургалтанд хамруулсан байна</p>	<p>ГУХ</p>
<p>4.1.5. Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн нэмэлт хөгжүүлэлтийн ажилд санал боловсруулж, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> 1</p> <p><b>Чанар:</b> Програм хангамжийн хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 дугаар сар</p>	<p>Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн нэмэлт хөгжүүлэлтийн ажилд санал өгсөн байна.</p>	<p>ГУХ</p>
<p>4.1.6. Шинээр томилогдож буй мэргэжилтэн, албан хаагчийг Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн гэрчилгээ олгох сургалтанд хамруулж, веб шалгалтанд бүртгэж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Тухай бүр</p> <p><b>Чанар:</b> Програм хангамжийн хүрээнд</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 дугаар сар</p>	<p>Шинээр томилогдож буй мэргэжилтэн, албан хаагчийг Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн гэрчилгээ олгох сургалтанд хамруулж, веб шалгалтанд бүртгэж, баталгаажуулах ажлыг</p>	<p>ГУХ</p>

		зохион байгуулсан байна	
4.1.7. Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллогыг шинэчлэн хийх, зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	<b>Тоо хэмжээ:</b> Зөрчилтэй нэгж талбарын тоогоор <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд <b>Хугацаа:</b> 2-12 дугаар сар	Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллогыг шинэчлэн хийж, зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулсан байна.	ГУХ
4.1.8. Төрийн өмчийн газрыг бүртгэх, зурагжуулах, мэдээллийн санд оруулах, баталгаажуулах ажлыг зохион байгуулах	<b>Тоо хэмжээ:</b> Тухай бүр <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд <b>Хугацаа:</b> 6-12 дугаар сар	Төрийн өмчийн газрыг бүртгэх, зурагжуулах, мэдээллийн санд оруулах, баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна.	ГУХ
4.1.9 Зөвшөөрөлгүй газар ашиглалтыг газар ашиглалтын зориулалт тус бүрээр илрүүлэн, судалгаа хийж, батлагдсан ажлын удирдамжийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	<b>Тоо хэмжээ:</b> 1 <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд <b>Хугацаа:</b> 5-7 дугаар сар	Эрх бүхий субъектын зөвшөөрөлгүй газар ашиглалтыг илрүүлэн, судалгаа хийж, батлагдсан ажлын удирдамжийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан байна	ГУХ
4.1.10. Орон нутгийн тусгай хэрэгцээний газрын судалгааг гарган ГЗБГЗЗГ-т хүргүүлэх, Газрын кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах	<b>Тоо хэмжээ:</b> Тухай бүр <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байх <b>Хугацаа:</b> 1-3 дугаар сар	Орон нутгийн тусгай хэрэгцээний газрын судалгааг гарган ГЗБГЗЗГ-т хүргүүлж, Газрын кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна	ГУХ
4.2. “Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэлийг хариуцаж, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг	<b>Тоо хэмжээ:</b> 1 <b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж, дүрэм,	Газрын нэгдмэл сангийн 2018 оны тайланг нэгтгэн ГЗБГЗЗГ-т ирүүлсэн байна	ГУХ



<p>бүртгэх, хянах” гол зорилтын хүрээнд</p> <p>4.2.1. Газрын нэгдмэл сангийн 2018 оны тайланг нэгтгэн ГЗБГЗЗГ-т ирүүлэх</p>	<p>журамд нийцсэн байх</p> <p><b>Хугацаа:</b> 1 дүгээр сар</p>		
<p>4.3 “Газрын биржийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, хяналт тавих” гол зорилтын хүрээнд:</p> <p>4.3.1. Газрын биржийн цахим системээр газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Тухайн бүр</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж журмын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 дугаар сар</p>	<p>Газрын биржийн цахим системээр газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа зохион байгуулсан байна</p>	<p>ГУХ</p>
<p>4.3.2. Газрын биржийн цахим системд өмнөх онуудын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, барьцаа, газрын зах зээлийн үнийн мэдээг бүрэн оруулах ажлыг зохион байгуулах</p>	<p><b>Тоо хэмжээ:</b> Тухайн бүр</p> <p><b>Чанар:</b> Холбогдох хууль тогтоомж журмын дагуу</p> <p><b>Хугацаа:</b> 1-12 дугаар сар</p>	<p>Газрын биржийн цахим системд өмнөх онуудын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, барьцаа, газрын зах зээлийн үнийн мэдээг бүрэн оруулах ажлыг зохион байгуулсан байна</p>	<p>ГУХ</p>
